



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/318

Арвайхээр

**Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн
батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хүүхдийн төлөө зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2.Аймгийн хэмжээнд Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих, хүүхдийн эрхийн талаарх асуудлыг хүүхдийн оролцоотойгоор авч хэлэлцэх, хүүхдийн оролцооны байгууллагыг дэмжин ажиллахыг Хүүхдийн төлөө зөвлөлийн нарийн бичгийн дарга (Ж. Энх-Амар)-д үүрэг болгосугай.

3.Сумдад хүүхдийн төлөө салбар зөвлөлийг шинэчлэн байгуулж, салбар зөвлөлийн дүрмийг батлах хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан “Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” аймгийн Засаг даргын А/522 дугаартай захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100681

Аймгийн Засаг даргын 2021 оны 06..
дугаар сарын 28.-ны өдрийн 4/318 дүгээр
захирамжийн хавсралт

АЙМГИЙН ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Хүүхдийн төлөө зөвлөлийн дарга –Аймгийн Засаг дарга
Нарийн бичгийн дарга -Аймгийн Засаг даргын дэргэдэх Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын дарга
Гишүүд: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн
дарга
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн
хэлтсийн дарга
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын
дарга
Аймгийн Онцгой байдлын газрын дарга
Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын дарга
Аймгийн Цагдаагийн газрын дарга
Аймгийн Цагдаагийн газрын хүүхдийн байцаагч
Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын эрүүл
ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч
Аймгийн Засаг даргын дэргэдэх Насан туршийн боловсролын төвийн
дарга
Өвөрхангай аймаг дахь Политехник коллежийн захирал
Аймгийн Хүүхдийн элч
Хүний эрхийн Үндэсний комиссын Өвөрхангай аймаг дахь салбар
зөвлөлийн мэргэжилтэн
Аймгийн Хүүхдийн нэгдсэн зөвлөлийн ахлах
Аймгийн Хүүхдийн нэгдсэн зөвлөлийн гишүүн